


Авлигатай холбоотой судалгаанд хийсэн дүн шинжилгээ



СИМОН
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ
ТАЙЛАН

2016

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Товчилсон үгс	3
Үндсэн ойлголт	4
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	5
Судалгааны зорилго, зорилтууд:	5
Судалгааны түүвэр, түүврийн хэмжээ:	6
Судалгааны хязгаарлагдмал тал	6
БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ҮР ДҮН	7
Хавсралт 1. Ашигласан судалгааны тайлангийн нэрсийн жагсаалт	14

ТОВЧИЛСОН ҮГС

АТГ	Авлигатай тэмцэх газар
ОУБ	Олон Улсын Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн Байгууллага
ТББ	Төрийн Бус Байгууллага
ИНБ	Иргэний Нийгмийн Байгууллага

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Нэр	Тайлбар
Авлига	Авлигын эсрэг хуулийн 3.1.1-д “авлига” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг ¹
Арга	Аливаа зүйлийг хийх (хийхээр төлөвлөсөн) арга зам
Арга зүй	Ямар нэг зүйл гүйцэтгэх аргын тайлбар
Ашиг сонирхлын зөрчил	Нийтийн албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол нийтийн ашиг сонирхолтой зөрчилдөх болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг ²
Бэлэг	Нийтийн албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх болон эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх, нийтийн албан тушаалтантай хамаарал бүхий этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг бусад хэлбэрийн санхүүгийн үр ашгийг; ³
Зорилго	<i>Төслийн</i> хувь нэмэр оруулахаар зорьж буй дээд түвшний <i>зорилго</i> . Ерөнхий зорилго.
Мониторинг/ Хяналт Шинжилгээ	Үйл ажиллагааг (ялангуяа үйл явцыг ерөнхийд нь) ажиглах, баримтжуулах, мөшгөх
Салбар	Үйл ажиллагаа эсвэл сонирхож буй салбар (субъект)
Судалгаа /survey/	Хувь хүн болон байгууллагаас цуглуулж буй мэдээлэл
Судалгаа /Research/	Шинэ мэдлэг, мэдээлэл бүтээхийн тулд хүний мэдлэг, соёл, нийгмийн талаар нөөц мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор системийн үндсэн дээр хэрэгжүүлж буй бүтээлч ажил ⁴
Үйл ажиллагаа	Үйл ажиллагаа буюу <i>оролт</i> -ыг <i>гаралт</i> болгон өөрчлөх үйл явц
Үр дүн	<i>Нөлөөллийн үйл</i> ажиллагаа-ны биет болон биет бус бүтээгдэхүүн
Үр нөлөө	Хүлээлт болон хэрэгцээний нийцэмжтэй байдал. Аливаа зүйлийг зөв хийх
Үнэлгээ /Evaluation/	Тодорхой стандартын дагуу үнэ цэнийг шалгах болон тодорхойлж явц Гүйцэтгэлийн үнэлгээ. <i>‘Тодорхой хөтөлбөрийн ач тус болон үнэ цэнийг тодорхойлоход ашиглаж буй системчилсэн үйл явц. Хөтөлбөр эсвэл тодорхой нөхцөл байдал дахь стратеги , Гуский, 2000</i>
Хээл хахууль	Хахууль авсан этгээд буюу оролцогч талаар ямар нэг шийдвэр эсвэл тодорхой нэг үйлдлийг зүй бусаар хийлгүүлэх зорилготойгоор өгсөн ашиг сонирхлын хэрэгсэл юм. ⁵
Шалгуур үзүүлэлт	Хэмжиж болохуйц хувьсах хэмжигдэхүүн

¹ <http://www.legalinfo.mn/law/details/8928>

² <http://www.legalinfo.mn/law/details/397>

³ <http://www.legalinfo.mn/law/details/397>

⁴ https://en.wikipedia.org/wiki/Research#cite_note-1

⁵ <http://www.transparency.mn/page/841.shtml>

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД:

Судалгааны ажлын гол зорилго нь 2006 оноос хойш хийгдсэн судалгааны арга зүй, хамрах хүрээ, зорилго зэрэгт дүн шинжилгээ хийх юм.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Авлигын эсрэг хуулийн шинэчлэлээс хойш хэрэгжсэн Авлигатай холбоотой судалгааны жагсаалт бүрдүүлэх;
- Судалгааны арга зүй, аргачлал, давуу сул талуудад шинжилгээ хийж харьцуулалт хийх;
- Судалгааны мэдээлэлд үндэслэн туршлага, үр нөлөө, үйл ажиллагаа зэрэгт шинжилгээ хийн, мэдээлэл цуглуулах,
- Авлигын чиглэлээр хийгддэг судалгааг сайжруулах талаар ярилцлага, хэлэлцүүлгээр үо дүнг танилцуулах, хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг нэгтгэн сайжруулах юм.

СУДАЛГААНЫ АРГА, ХАМРАХ ХҮРЭЭ:

Судалгаа нь чанарын буюу баримт бичгийн судалгааны аргыг ашиглан авлигатын чиглэлээр хийгдсэн судалгаануудын ерөнхий мэдээлэлд шинжилгээ хийсэн. Судалгааны мэдээллийг боловсруулахдаа дараах төрлийн мэдээллийн загварыг ашигласан. Судалгааны агуулгын хүрээ нь үндсэн 10 ерөнхий сэдвээс бүрдэж байна. Эдгээр нь сэдвүүд нь ажлын даалгаварт тусгагдсаны дагуу авлигатай холбоотой судалгааны талаар ерөнхий мэдээлэл, судалгааны арга зүйтэй холбоотой, судалгааны мэдээлэлд шинжилгээ хийх, сайжруулах санал зөвлөмж боловсруулах гэсэн үндсэн 4 агуулгад хуваагдана.

Судалгааны ажлын даалгаварт тусгагдсаны дагуу дараах зорилтот үзүүлэлтүүдийг дэвшүүллээ.

Түвшин	Тодорхойлолт	Шалгуур үзүүлэлтүүд
Зорилт 1	Авлигын эсрэг хуулийн шинэчлэлээс хойш хэрэгжсэн Авлигатай холбоотой судалгааны жагсаалт бүрдүүлэх	Он сар /тогтмол эсэх/ Захиалагч, гүйцэтгэгчийн мэдээлэл Төрөл, ангилал
Зорилт 2	Судалгааны арга зүй, аргачлал, түүвэрт шинжилгээ хийж, харьцуулах	Хамрах хүрээ Аргачлал Түүвэр
Зорилт 3	Судалгааны туршлага, үр нөлөө, үйл ажиллагаа зэрэгт шинжилгээ хийн, мэдээлэл цуглуулах	Зорилго Үндсэн ойлголт Давуу болон сул тал Агуулга
Зорилт 4	Авлигын чиглэлээр хийгддэг судалгааг сайжруулах талаар ярилцлага, хэлэлцүүлгээр үо дүнг танилцуулах, хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг нэгтгэн сайжруулах	

СУДАЛГААНЫ ТҮҮВЭР, ТҮҮВРИЙН ХЭМЖЭЭ:

Мэдээлэл цуглуулалтын хүрээнд нийт 45 судалгаа, шинжилгээний нэрс цугларсанаар олон улсын түвшний авлигын индекс, авлигатай шууд хамааралтай бус, арга зүйтэй холбоотой шаардлагатай мэдээлэл хязгаарлагдмал, судалгааны тайлан олдоогүй зэрэг нөхцлүүдийг харгалзан 35 судалгааны мэдээлэлд шинжилгээ хийсэн.

СУДАЛГААНЫ ХЯЗГААРЛАГДМАЛ ТАЛ

Төслийн суурь судалгааны мэдээллийг цуглуулах явцад анхаарвал зохих хэд хэдэн хязгаарлагдмал байдал байсныг дурьдах нь зүйтэй.

Мэдээлэл цуглуулалтын хувьд:

- Судалгааны мэдээллийг цуглуулахдаа холбогдох байгууллагын веб хуудас, интернэтийн бусад сайтууд болон ИРИМ судалгааны хүрээлэнгийн архивт байгаа мэдээллүүдийг ашигласан.
- Судалгааны мэдээллийн онцлогоос шалтгаалан олон улсын түвшинд хийгддэг харьцуулсан болон индексийн судалгаануудыг хассан.
- Авлигатай шууд холбогдоогүй ч зарим хэсгүүдэд авлигатай холбоотой асуултын үр дүнгийн талаар мэдээлэл орсон судалгаануудыг хассан.

Агуулгын хувьд:


- Захиалагчийн боловсруулсан ажлын даалгаварт тусгагдсан мэдээллийн хүрээнд мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийсэн.

БҮЛЭГ 1. ЕРӨНХИЙ ҮР ДҮН

Энэ бүлэгт 35 судалгааг 10 ангилалаар харьцуулан боловсруулсан мэдээллийн үр дүнг нэгтгэн орууллаа.

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтээс хойш энэ чиглэлийн судалгааны ажлууд нилээд эрчимжсэнтэй холбоотойгоор олон төрлийн авлигын чиглэлийн судалгаанууд хийгджээ. Энэ судалгаанд 2002 – 2006 оны хооронд хэрэгжсэн 8 төрлийн судалгаа, 2006 оноос хойш хэрэгжсэн 27 судалгааг хамруулсан.


Дүрс 1 Авлигын чиглэлээр хийгдсэн судалгааны он (тоогоор)



2013 оноос хойш Авлигын чиглэлээр хийгдэж буй судалгааны тоо өсчээ. Үүнээс харахад Монгол улсад авлигын асуудал жил ирэх тусам хурцдаж, олны анхаарлыг татсан асуудал болж байгааг илтгэж байгаа ч, нөгөө талаар авлигын асуудлыг чухалчлан авч үзэх, авлигын асуудлаар үйл ажиллагаа явуулах, авлигыг бууруулах чиглэлд олон талууд оролцох болсоныг харуулж байна.

Дүрс 2 Тогтмол хийгддэг авлигын судалгааны давтамж (тоогоор)

Дээрх 35 судалгаанаас 27 нь буюу 73 хувь нь нэг удаагийн давтамжтай хийгдсэн бол 8 судалгаа буюу 27 хувь нь тогтмол хийгддэг байна. Тогтмол хийгддэг нийт 8 судалгааг цаг хугацааны давтамжийн хувьд харьцуулж харвал:




Авлигатай тэмцэх газар, Азийн сан, ЭЗХАХБ зэрэг байгууллагууд авлигатай холбоотой судалгааг тогтмол хийж гүйцэтгэж байна.

Хүснэгт 1 Тогтмол авлигын судалгаа хийдэг судалгаа болон байгууллагын нэр (тоогоор)

№	Байгууллага	Тоо	Судалгааны нэр
1	Авлигатай тэмцэх газар	5	<ul style="list-style-type: none"> Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгаа Авлигын индекс Хүүхдийн шударга байдлын судалгаа Улс төр, хууль, хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаархи төсөөллийн судалгааны тайлан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний тайлан
2	Азийн сан	2	<ul style="list-style-type: none"> Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал Авилгын талаархи олон нийтийн ойлголт, мэдлэгийг тогтоох судалгаа
3	ЭЗХАХБ	1	<ul style="list-style-type: none"> Монгол дахь авлигын эсрэг шинэчлэл үнэлгээ


Авлигатай холбоотой судалгааг Монгол улсад хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч гэсэн 3 түвшинд авч үзсэн. Судалгааны үр дүнгээс харахад авлигын судалгааны 94 хувийг олон улсын болон төрийн байгууллагууд захиалан, сонгон шалгаруулалтын аргаар ихэвчлэн хувийн хэвшлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж байна. Судалгааны мэдээлэл боловсруулалтын хүрээнд захиалагч, гүйцэтгэгч тодорхойгүй байх тохиолдол гарч байв. Мөн судалгааг өөрсдөө хэрэгжүүлдэг төрийн байгууллагууд нилээд байсан учраас тэдгээрийг захиалагч болон санхүүжүүлэгчийн түвшинд давхардуулж оруулаагүй. Дараах хүснэгтээс олон улсын байгууллага, төрийн байгууллага, хувийн хэвшлийн авлигын судалгааны чиглэлээр гүйцэтгэж байгаа үүргүүдийг харж болно.

Дүрс 3 Байгууллагын төрөл болон үндсэн үүрэг (тоогоор)




Судалгааны үр дүнд мэдээлэл боловсруулсан нийт 35 судалгаанаас судалгаа 27, үнэлгээ 8 байсан. Судалгааг төрлөөр нь ангилавал бодлогын судалгаа, индекс, харьцуулсан судалгаа гэх мэт олон төрөл байгаа бөгөөд хамгийн олон нь олон нийтийн санал бодолд суурилсан судалгаа 8 хийгдсэн байна. Мөн нийт 8 төрлийн үнэлгээний ажил хийгдсэн байгаагаас 4 нь мониторинг буюу хяналт шинжилгээ хийх чиглэлээр, бусад 4 үнэлгээ нь байгууллага, албан тушаалтнуудыг үнэлсэн байна.

Дүрс 4 Судалгааны төрөл (тоо/хувиар)




Дээрх судалгаа, үнэлгээний ажлыг хамарсан салбар, чиглэлээр нь авч үзвэл дийлэнх буюу 13 нь төрийн захиргааны байгууллагын үйлчилгээ, албан хаагчид зэрэг төрийн байгууллагуудыг хамарсан судалгаанууд байна. Жишээлбэл Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдал, Төрийн байгууллагын шударга байдлыг түвшинг үнэлэх гэх мэт. Мөн 2 болон түүнээс дээш салбарыг хамарсан тохиолдолд салбар дундын гэж тооцсон бөгөөд нийт 8 судалгаа хийгджээ. Жишээлбэл Авлигын хандлагын судалгаа, Авлигын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа, Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь, Авлигын индекс, Авлигын ерөнхий төлөв байдлын судалгаа гэх мэт. Гааль, боловсрол, газар, уул уурхайн салбартай холбоотой авлигын судалгаанууд мөн тогтмол хийгдсээр иржээ.

Дүрс 5 Авлигын судалгааны салбар (тоо/хувиар)



Судалгаанд оролцогчдын түүврийн хувьд давхардсан тоогоор 50 төрлийн оролцогчдыг хамруулжээ. Үүнээс 34 хувь нь төрийн албан хаагч, 28 хувь нь иргэд, олон нийт байна. Бусад гэсэн үзүүлэлтэнд ИНБ, ОУБ-ийн албан хаагчид, сэтгүүлчид зэрэг төлөөллийг багтаасан.

Дүрс 6 Судалгаанд оролцогчдын ангилал (тоо/хувиар)



Нийт 35 судалгааны 3 судалгаа нь Орхон, Хэнтий, Нийслэл Улаанбаатарыг хамарсан бол үлдсэн 32 буюу 91 хувь нь Үндэсний хэмжээнд⁶ хийгдсэн. Үүнээс 15 судалгааны мэдээлэл цуглуулалт Улаанбаатар хот болон орон нутаг аль алийг нь хамруулжээ.

Хүснэгт 2 Судалгааны хамрах хүрээ (тоогоор)

Үндэсний хэмжээнд	32	17	Улаанбаатар
		15	Орон нутаг, Улаанбаатар
Орон нутгийн хэмжээнд	3	Хэнтий, Орхон, Улаанбаатар	

Нийт судлагдсан 35 судалгаа нь давхардсан тоогоор 65 аргыг ашигласан бөгөөд энэ нь дунджаар нэг судалгаа 2 төрлийн аргыг ашигладаг байна. Авлигын сэдвийн онцлогоос шалтгаалан судалгааны мэдээллийн 66 орчим хувь нь чанарын аргыг ашиглажээ.

Дүрс 7 Судалгааны мэдээлэл цуглуулалтанд ашигласан арга (тоо/хувь)



Дээрх 35 судалгааны зорилгыг дараах зургаан түвшинд нэгтгэсэн. Судалгааны онцлогоос хамааран хэд хэдэн чиглэлийн зорилгыг дэвшүүлсэн тул давхардсан тоогоор 46 төрлийн агуулгыг багцалсан. Үүнд:

Хүснэгт 3 Судалгааны зорилгыг нэгтгэсэн байдал (тоо/хувь)


Авилгалын түвшин, цар хүрээг тодорхойлох	10 (21.7%)
Авлигын шалтгаан, эх үүсвэрийг тодорхойлох, эрсдлийг үнэлэх	5 (10.9%)
Авлигалын талаархи олон нийтийн ойлголт, төсөөлөл, хандлагыг тодруулах	10 (21.7%)
Авлигалтай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг үнэлэх	8 (17.4%)
Төрийн байгууллагуудын нээлттэй ил тод үйл ажиллагааг үнэлэх, үйлчилгээний хүндрэл, хүнд суртал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулах,	6 (13%)
Авлигатай тэмцэх чиглэлд тулгамдаж байгаа асуудлыг тодруулж, нөхцөл байдлыг сайжруулах арга замыг санал болгох	7 (15.2%)

Монгол улсад хэрэгжсэн авлигын чиглэлээрх судалгааны 43.4 хувь нь авлигын түвшин тогтоох болон олон нийтийн ойлголт, төсөөллийг судлах зорилготой байлаа. Харин асуудлыг гүнзгийрүүлэн тодруулж, нөхцөл байдлыг сайжруулах арга замыг санал болгох зорилготой судалгаа 15 орчим хувьтай байна.

Дээрх зорилгуудын хүрээнд судалгааны мэдээлэл цуглуулахад ямар үндсэн ойлголт ашиглаж байгаа талаар дараах дүрсээр харууллаа.

⁶ Үндэсний хэмжээнд гэдэгт улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, албан хаагчдыг хамруулсан судалгааг оруулж тооцсон.

Дүрс 8 Үндсэн ойлголт (тоо/хувиар)



Дээрх үр дүнгээс харахад авлигын чиглэлээр судалгаа хийхэд тухайн салбарын онцлог болон бусад хүчин зүйлээс шалтгаалан шууд авлига гэж томъёолохгүйгээр харин хээл хахууль, бэлэг, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил зэрэг томъёоллыг ашиглан тойруу байдлаар авлигыг судалж байгаа тохиолдол нийт судалгааны тал орчим хувийг эзэлж байна.

Ажлын даалгаварт тусгагдсанаар нийт судлагдсан 35 судалгааны агуулгыг гүнзгийрүүлэн судлахгүй учраас давуу талыг давхардсан тоогоор харьцуулалт хийсэн эсэх, түүвэр хангалттай төлөөлж байсан эсэх, оновчтой арга зүй ашигласан эсэх, судалгааны үр дүнг тархаасан эсэх зэрэг ерөнхий мэдээллүүдээр багцаллаа.

Хүснэгт 4 Давуу тал (тоо/хувиар)

№	Давуу тал (давхардсан байдлаар)	Хувь
1	Судалгааны үр дүнг олон нийт болон холбогдох байгууллагын төлөөлөлд танилцуулах, тархаах ажил хийгдсэн	13 (21%)
2	Хэрэгцээтэй мэдээллийг цуглуулж чадсан, мэдээллийн сан бүрдүүлсэн	10 (16.6%)
3	Судалгааны үр дүнг бусад төрлийн судалгаа, салбар, улс орон зэрэг өөр хүчин зүйлүүдтэй харьцуулсан	8 (13.3%)
4	Түүврийг хангалттай хэмжээнд, оновчтой сонгож чадсан	8 (13.3%)
5	Бусад	21 (35%)

Судалгаа тус бүрийн сул талыг агуулгын хувьд нарийн тодорхойлоогүй боловч дүгнэлт, санал зөвлөмж гаргасан эсэх, ямар нэгэн чиглэлээр харьцуулалт хийгдсэн эсэх зэрэг ерөнхий мэдээллийг харгалзан үзээд дараах ерөнхий үр дүнг гаргалаа.

Хүснэгт 5 Сул тал (тоо/хувиар)

№	Сул тал (давхардсан байдлаар)	Хувь
1	Санал зөвлөмж гаргаагүй	13 (44.8%)
2	Ямар нэгэн чиглэлээр харьцуулалт хийгдээгүй	5 (17.3%)
3	Бусад	12 (37.9%)

Авлигын түвшин цар хүрээг үнэлэх, олон нийтийн хандлага мэдлэг тогтоох чиглэлийн судалгаанууд нь ихэвчлэн судалгааны үр дүнг тайлбарлан, дүгнэжээ. Судалгааны сул талыг гаргахдаа голчлон санал зөвлөмж байгаа эсэх дээр суурилсан. Судалгааны үр дүнг үндэслэн холбогдох хувь хүн, албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг авах арга хэмжээний талаар санал зөвлөмж боловсруулж байх нь судалгааны үр дүнг бодитойгоор ашиглах нэг арга юм.

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮР ДҮН

АСУУЛТ ХАРИУЛТ

Асуулт1: Судалгааны дунд 2010 оны судалгаа бий юу? Яагаад ийм цөөхөн байгаа вэ?

Авилгалтай тэмцэх газрын “Төрийн байгууллагын шударга байдлын үнэлгээ” –ний судалгаанд 2010 оны судалгаа яагаад орхигдсон бэ? Судалгааны хамрах хугацаа, судалгааны үр дүн гарсан он нь өөр өөр, тайлан мэдэгдэж гарсан хугацаагаа тавиад байгаа юм уу?

Хариулт 1: Тухайн судалгаанууныг цуглуулж аваад тайлан дээр байсан оныг нь оруулж өгсөн. Судалгаа хэвлэгдсэн он уу, эхэлсэн он уу гэдэг нь тухайн тайлан дээр тавигдсан байгаа оноор нь оруулж өгсөн. Давтамжтай хийгдсэн судалгаануудыг бол анхны эхэлсэн жилээс нь тооцсон.

Асуулт2: Авилгатай тэмцэх газрын судалгаа шинжилгээний албаны хүмүүстэй уулзсан уу?

Хариулт 2: Дүн шинжилгээ хийхдээ ямар нэгэн байгууллага, албан тушаалтантай уулзаагүй. Баримт бичгүүдээ ихэвчлэн онлайн-аар цуглуулсан.

СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ӨГСӨН ЕРӨНХИЙ САНАЛ

Санал 1: Онлайн-аар баримт бичиг цуглуулахад судалгааны давуу сул талуудыг дүнгэхэд хүндрэлтэй байдаг.

Санал 2: Эх үүсвэрүүд хангалттай бус, нэр томъёоны тайлбар нь Wikipedia-аас авсан байгаа чинь хангалттай тайлбар байж чадахгүй байна. Судалгааны нэгдсэн арга зүйтэй болох.

Санал 3: 2007 онд үндэсний хэмжээнд хийгдсэн “Төрийн байгууллага дахь хүнд суртал”-ын судалгааг тайландаа оруулж өгөх хэрэгтэй байсан.

Санал 4: Гадаадын сайтуудаас судалгааны тайлангуудыг үзэж ямар аргачлал, арга зүйгээр хийсэн байгааг нь үзээд хэрэгжүүлсэн бол их зүгээр байлаа. Жишээ нь Трансперенси Интернэшнлийн.

АВЛИГЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДДЭГ СУДАЛГААГ САЙЖРУУЛАХАД ӨГСӨН ЕРӨНХИЙ САНАЛ

Санал 1: Авлигын ойлголт тодорхойлолтын асуудлаа нэг стандартад оруулж цэгцлэх хэрэгтэй.

Санал 2: Судалгаа хийхдээ хууль эрх зүйн баримтуудыг сайн судалж үздэг байх хэрэгтэй.

Санал 3: Судалгаа хийхдээ арга зүй, аргачлалаараа дамжуулж Хүмүүсийн Төсөөллийг нь өөрчлөх хэрэгтэй. Ихэвчлэн төсөөллийн судалгаа хийгдээд байна.

Санал 4: Авилгалтай тэмцэх газар авилгалтай холбоотой хийгдсэн бүх судалгаануудаа нэгтгээд нэг мэдээллийн нэгдсэн сантай болж аргачлалуудаа сайтан дээрээ тавих хэрэгтэй.

Санал 5: Судалгаанд хамрагдсан он, судалгааны үр дүн гарсан он, аль байгууллага судалгааг хийсэн гэдгээ бичиж хүснэгтлээд нүүрэнд нь тавьчихвал заавал орж хараад байх шаардлагагүй болно.

Санал 6: Авилгалын цар хүрээг тогтоож, ангилж өгөх хэрэгтэй.

Санал 7: Эрүүгийн гэмт хэргийн дундаас авилгал хийсэн арга, юу хийсэн гэдгийг нь судлах. Дээд түвшний авилгалыг судлахын тулд эрүүгийн гэмт хэргийн шүүхээр шийдэгдсэн хэргүүд ямар замаар үйлдэгдсэн, энэ хүн юу хийдэг вэ гэдгийг нь гаргаж ирж эрүүгийн хэргийг үзэх хэрэгтэй.

Санал 8: Кабинетийн зарчмын гүнрүү нь орж судлах.

Санал 9: Авлига албан тушаалтны асуудал дээр анализ хийх.

Санал 10: Танай төсөл бусад төсөл болгоноос нэг шинжээчдийг аваад эрүүгийн хэргийн бодитой байдлыг судлах баг бүрдүүлэх хэрэгтэй.

Санал 11: Судалгаа авахдаа тодорхой нэг асуудлыг барьж аваад тодорхой нэг зүйлийг ярьж баймаар байна.

Санал 12: Прокурор хэрэгсэхгүй болгосон хэрэг, шүүх дээр цагаадсан хэргийг үзвэл эрүүгийн хэргийн чиг хандлагыг харж болно.

Санал 13: Тухайн асуудлыг төсөөллөөр судлах биш Бодит байдлын судалгаа хийж жинхэнэ бодит үр дүнг гаргадаг болох.

Санал 14: Тухайн судалгааны үр дүнг удирдлагууд нь ашигладаг, дараагийн судалгаандаа хэрэглэдэг, хардаг болчихвол судалгааны жинхэнэ үр дүн гарна.

Санал 15: Шүүгчид мэдээллээ нээлттэй болгох, Иргэд хариуцлагатай байж нийтэлсэн үр дүнг хардаг байж сайн засаглалыг цогцлоох болно.

Санал 16: Судалгааны мэдээлэл солилцдог сувагтай болох хэрэгтэй.

Санал 17: hamtdaa.mn сайтыг ашиглаж мэдээлэл солилцдог болох.

Санал 18: Индекстэй холбоотой судалгааны арга бол тодорхой байдаг, харин мониторинг болон төсөөллийн судалгааны арга зүйг чиглүүлж өгвөл зүгээр.

Санал 19: Сэдэвчилсэн судалгаанууд хийх.

Санал 20: Докторын болон магистрын ажлуудыг мэдээллийн сандаа сайн шалгаж оруулж байх.

ХАВСРАЛТ 1. АШИГЛАСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Судалгааны нэр	Холбогдох линк
1	МУ-дахь авлигалын байдалд хийсэн үнэлгээ	http://pdf.usaid.gov/pdf_docs/Pnad
2	Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээ	Хэвлэмэл тайлан
3	Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал /STOPP/	http://asiafoundation.org/resources
4	Авлигын талаархи олон нийтийн ойлголт, мэдлэгийг тогтоох судалгаа /SPEAK/	https://asiafoundation.org/resource
5	Геоземи, Картограф болон Газрын албаны ил тод байлыг сайжруулах судалгаа	Хэвлэмэл тайлан
6	Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдлын судалгаа	Хэвлэмэл тайлан
7	Монгол улсын байгалийн нөөцийн менежмент дэх авлига	http://www.transparency.org/files/content/corruptionqas/354_Corruption_in_natural_resources_management_Mongolia.pdf
8	Монгол дахь Авлигын эсрэг шинэчлэл: үнэлгээ	Хэвлэмэл тайлан
9	Монгол улсын шүүхийн авлигын тухай зарим асуудал	http://www.opensocietyforum.mn/res_mat/Judicial%20Corruption%20in%20Mongolia.pdf
10	Авлига соёлын үзэгдэл болох нь: Хуучин ЗХУ-ын эзэнт гүрнээс өөр улс орнуудын эмпирик судалгаа	http://alsb.roundtablelive.org/Resources/Documents/NP%202002%20Nichols-Siedel-Kasdin.pdf
11	Улс төр, хууль, хяналтын байгууллагын хүрэн дэх авлигын талаархи төсөөллийн судалгааны тайлан	http://www.iaac.mn/pdf/ssha/Report_CPPLS_2014_new.pdf
12	Төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлэх судалгаа	http://www.iaac.mn/content/577#.VyWB09R94dU
13	Авлигын индекс	http://www.iaac.mn/pdf/ssha/RESULT_REPORT_OF_MCI_2013_eng.pdf
14	Хүүхдийн шударга байдлын судалгаа	http://www.iaac.mn/pdf/ssha/Child_Integrity_2013_report.pdf
15	Авлигын ерөнхий төлөв байдлын судалгаа	http://www.iaac.mn/pdf/ssha/Abstract_Report.pdf
16	Гаалийн байгууллагын ажилтнуудаас авсан судалгаа	http://www.iaac.mn/content/239#.VzM-iCGHjIV
17	Газрын албаар үйлчлүүлж буй байгууллага иргэдээс авсан судалгаа	http://www.openforum.mn/pdf/public_meeting/sudalgaairged.pdf
18	Авлигын эсрэг НҮБ-н конвенцын 2-р бүлгийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах нь	http://www.iaac.mn/pdf/nub/Convention_2.pdf
19	Улс төрийн хүрээний авлигалын индекс	Хэвлэмэл тайлан
20	Авлигалын индекс	Хэвлэмэл тайлан
21	Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга хэмжээ	http://www.forum.mn/res_mat/BayaraaAbuseFinal_mn.pdf
22	Төрийн худалдан авах үйл ажиллагаа болон авлига	http://www.forum.mn/res_mat/procurement.pdf
23	Албан тушаалтын гэмт хэрэгт хамаарагсдын нийгмийн хор аюул,гэднийг илрүүлэх нь	http://www.iaac.mn/pdf/ssha/iltgeluud_2011/iltgel18.pdf

24	Авлигын хандлагын судалгаа	http://www.erdenet.mn/userfiles/file/AVLIGIIN%20XANDLAGIIN%20SUDALGAA%202014.pdf
25	Авлигалыг дэмжигч ба хориглогч хүчин зүйлсийн судалгаа	ХЭВЛЭМЭЛ тайлан
26	Авлига ба өндөр түвшний авлига	http://www.iaac.mn/pdf/book/avliga_undesnii_ayulgui_baidal.pdf
27	Хэнтий аймгийн Баянмандах суманд хийсэн авлигын тандалт судалгааны тайлан	http://www.globeinter.org.mn/images/upld/khentii_avilga.pdf
28	Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдал-мониторингийн тайлан	http://www.iaac.mn/pdf/tailan/glob_monitoring.pdf
29	Замын үүд, Алтанбулаг боомт хотын гаалийн албад болон УБ хотын толгойтын гүнийн гаалийн албаны үйл ажиллагаанд мониторинг хийх	https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=3&cad=rja&uact=8&ved=0ahUKEwjQm7D5m9LMAhVJahoKHVykAKQQFggoMAI&url=http%3A%2F%2Fforum.mn%2Fforum_topics%2Fp_ZorigSan.doc&usg=AFQjCNFMeMlga_3kr70s5AogBR158Cz32w&sig2=eRWqK2d9P3c1hsUICHJ0Kw
30	Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь	http://www.iaac.mn/pdf/book/avliga_undesnii_ayulgui_baidal.pdf
31	Монголын өдөр тутмын хэвлэлүүд дэхь авлигын сэдэвт нийтлэл, мэдээлэл хийсэн контент анализ	https://zorigtsoc.wordpress.com/2009/04/29/
32	“Авлигалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилт /мониторингийн судалгаа/	http://www.forum.mn/res_mat/res_mat-141.pdf
33	Нийслэл хот авлигын эсрэг	https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=2&cad=rja&uact=8&ved=0ahUKEwismJ7OrOrMAhViqYKHXv9DWsQFggkMAE&url=http%3A%2F%2Fubstat.mn%2FUpload%2FReports%2Fniislel_khot_avligiin_esreg_2008_ulaanbaatar_2008-12.pdf&usg=AFQjCNF11omEqvaB6kIfE_J00LMzbU1mag
34	Авлига, төрийн албаны хүнд суртал, төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлаар хийгдсэн судалгааны тойм	https://www.google.com/url?sa=t&rct=j&q=&esrc=s&source=web&cd=1&cad=rja&uact=8&ved=0ahUKEwismJ7OrOrMAhViqYKHXv9DWsQFggdMAA&url=http%3A%2F%2Fwww.parliament.mn%2Ffiles%2Fdownload%2F155188&usg=AFQjCNE-CWNLSWeIA9CX9SiQkFZt0Tr7rw
35	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний тайлан	http://iaac.mn/pdf/unelgee/2015/turiin_umchit_unelgee.pdf